

## **АВАР, (ПСЕВДО)АВАР, (А)ПАРЫН ТУХАЙ**

**Б.БАТСҮРЭН**

*ШУА-ийн Түүхийн хүрээлэн  
e-mail: bbarangas@yahoo.com*

*Түлхүүр үг: Авар, псевдоавар, савир, кермихионит, ухуань, сяньби, жоужань, аварга, могой*

*Өгүүллийн товч агуулга: Өрнийн сурвалж бичгүүдэд авар нэрээр V зууны үед тэмдэглэгдсэн овог аймаг болон VI зууны үед мөн Византи, Франк зэрэг өрнийн орнуудын түүх сударт тэмдэглэгдсэн псевдоавар нарын хоорондын удам гарлын холбоо хийгээд VI зууны дундуур мөхсөн Жоужань улсын үндсэн хүн амтай хэрхэн холбогдох талаар өгүүлнэ. Түүнчлэн эртний түрэгийн бичиг үсгийн дурсгалд нэр гарсан апартай ямар хамааралтай болох тухай өгүүлэхийг зорилоо.*

Төв Азид ноёрхлоо IV зууны эхнээс тогтоож байсан жоужань нар “555 онд [түрэгт] хиар цохигдсоноос хойш ... үндсэн хүн ам нь түрэгийн харьяанд орж, нэг хэсэг нь гурван түмээд өрх (130-аад мянган ам) түрэгт захирагдахыг үл хүсэн өрнө зүгт зугадан гарч ... Обор буюу Авар гэдэг нэрээр 558 оноос европ бичиг сударт тэмдэглэгдэх [болсон ба] авар нар тухайн үед мөхөн доройтож агсан Римийн хаант улсын нутагт аажмаар нэвтрэн орж, Кавказын уулаар одож, нутаглан суусан нь өнөөгийн Аварчуудын өвөг дээдэс болсон” (БНМАУ-ын түүх, 1966: 114; Ишжамц, 1998: 17; Монгол Улс, 2003: 304-305; Хандсүрэн, 2005: 29-30) гэж манай түүх бичлэгт үзсээр иржээ.

Гэтэл энэ нь үнэндээ бол ойролцоо нэрээр түүхэнд тэмдэглэгдсэн овог, аймгийг хольж хутгаснаас үүдэлтэй үзэл баримтлал бөгөөд барууны голдуу судлаач Авар нэрээр түүхэнд тэмдэглэгдсэн овог аймгууд хоорондоо хэрхэн хамааралтайн тухай судалгааг эрт эхлүүлжээ.

**Нэг. «Авар (463 он)»:** Аварын талаарх грек тэмдэглэлүүд Priscus-аас эхлэн Suidas (s.v. “Αβαρίς) болон Constantine Porphyrogenetos нарын өгүүлсэн зохиолуудад дурдсанаар бол, Сарагур (Σαραγούροι), Угор (Ουγούρ, Ογώρ), Оногур (Ονογούρ, Ονοουγούρ) нар 461-465 оны хооронд Авараас зугтсан Савируудын довтолгооны улмаас нутгаасаа хөөгджээ. Харин Аварууд, далайн эрэгт, тэнгис далайгаас дэгдэгч их манан будант оронд нутаглагч нэгэн аймаг, гэнэт хүний махан хүнст Грифоны\* довтолгоонд өртсөний улмаас нутгаа орхин тэдний нутагт довтолон орсноос газар нутгаа алдан өрнө зүг зугтжээ. Өөрөөр хэлбэл, Византийн сурвалж дахь “463 онд Римд хүрэлцэн ирсэн ‘сарагур’, ‘угор’, ‘оногур’ аймгийн элч, далайн эрэгт оршигч нэр үл мэдэгдэх ард түмнээс зугтаасан ‘авар’ нарт түрэгдэн шахагдсан ‘савир’-уудад

\* Ἄλδᾰυᾰέεῖ ὀῖεᾰῖεῖῖε, ἄῖῖεᾰῖ ἄεᾰῖεᾰᾰᾰ-ῖᾰε ῖεᾰῖῖ ἄῖῖεῖῖ ἄῖῖῖᾰῖᾰ Ἀῖῖεῖῖ (Gryphon) ἄῖῖῖᾰ.

хөөгдөн төрөлх нутгаа орхисон тухай өгүүлсэн” гэх мэдээтэй холбогдон анх ‘Авар’ нэр тэмдэглэгджээ (Macartney, 1944: 266; Hamilton, 1962: 33; Артамонов, 2002: 86).

Төв Азид өрнөсөн үйл явдлаас шалтгаалан үүссэн нүүдлийн энэхүү гинжин хэлхээнд ‘сарагур’, ‘угор’, ‘оногур’ нар хамгийн сүүлд өртөн гэхдээ хамгийн түрүүнд Византийн хил, Хар тэнгисийн хойд хэсэгт нүүдэлдэн иржээ. Эдгээр гурван аймгийг нэлээд судлаач хожмын уйгуруудтай холбохыг хичээдэг. Тухайлбал, James Hamilton, сарагур, оногур, угор/огор нарыг сариг-уйгур, он-уйгур, уйгур хэмээн үзсэн байдаг (Hamilton, 1962: 33-34). Гэхдээ түүний энэ үзэл баримтлал шинэ зүйл биш бөгөөд В.В.Радлов сарагур, оногур ба угор нарыг дорнод түрэгүүд ө.х. уйгур аймаг бөгөөд эдгээр дорнод түрэгчүүд ‘гунн’ нэрийн дор IV зуунд Европт нэвтэрсэн гэж үзжээ. Харин эдгээр аймгийг Д.Европеус уйгур биш харин угорууд гээд сарагур нэрийг вогул хэлээр цагаан угор, оногурыг их угор гэж тайлбарлан тэд Поволж, Приуралын тал хээрт оршиж байсан гэсэн бол М.И.Артамонов, сарагур бол уйгур биш харин түрэг элемент холилдсон угор гэжээ.

Харин М.И.Артамонов, тэднийг нутгаас нь элдэн хөөсөн ‘савир’-ыг “баруун Сибирийн зүүн хойд хэсэгт оршиж байсан бололтой. Тоболийн татарын дунд, Эрчис мөрний дунд, доод нутгийг ‘сывыр’ эсвэл ‘сибыр’ гэх ард түмэн эзэлж байсан тухай хууч домог тархсан байдаг. Бас вогулын ‘манси’ нарын нөгөө нэрийг «сипир» гэдэг. Үүнээс үзвэл эрт цагт уг нэр нь тэдний нэр хочоос урган гарсан ба ‘савир’, ‘сабир’ гэж баруун Сибирийн угор хүн амыг нэрлэж байжээ” (Артамонов, 2002: 89, 91) гэж өгүүлжээ.

Савирууд мөн л сарагур, оногур, угор нарын араас нүүдэллэн ирсэн хэдий ч тэд Каспийн тэнгисийн баруун суга, Кавказын араар голчлон нутаглажээ.

Сирийн Захар Ритор гэгч хүмүүний VI зууны дундуур бичсэн он дарааллын бичигт дээрх аймгууд бусад нүүдэлчдийн хамтаар, тухайлбал, “аунгур, аугар, савир, бургар, куртагар, авар, хазар, дирмар, сиригур, баграсик, кулас, абдел ба эфталит [ünugūr, sab(i)r, bürg(a)r, kūrtrg(u)r, ab(a)r, kas.r, dirm.r, sarürgūr, bāgrsig, küls, abd.l, ept(a)lit] гэж тэмдэглэгджээ. Бага зэрэг хувирч гажсан хэдий ч энэ сурвалжийн жагсаалтаас–оногур, огор, савир, болгар, кутригур, авар, хазар, сарагур, эфталит гэсэн нэрийг төвөггүй мэдэж болно” (Hamilton, 1962: 35; Артамонов, 2002: 104-105).

Түүнчлэн, одоогийн ОХУ-ын Саратов хотын орчим малтсан булшны антропологийн хэрэглэгдэхүүнээс үзвэл монгол төрх илэрдэг бөгөөд цаг хугацааны хувьд IV-VI зуунд буюу Сарагур, Савир нарынх байж болох бөгөөд нас барсан эрчүүдийг, адууны толгой дөрвөн шийр бас 1.65 м хүртэл урттай хүннү нум, сумны үлдэгдэлтэй оршуулдаг, оршуулгын зан үйлийн шинэ үзэгдэл гэнэт бий болсон байна. Гэтэл урьд буюу ‘гунн’-ы үед холбогдох оршуулгад хүнээ чандарлаж нутаглуулах үзэгдэл зонхилжээ (Артамонов, 2002: 120-121).

Аварын довтолгооноос шалтгаалж нүүсэн дөрвөн аймгийн талаарх судалгааг нэгтгэн үзвэл Эрчис мөрнөөр нутаглаж байсан Савир нарыг Аварууд 461 оны үед довтлон нутгаас нь шахсан ба харин тэд дараа нь Төв Казахстан, Урал орчмоор нутаглаж байсан, индо-иран болон түрэг элемент агуулсан финн-угоруудыг нутгаас нь шахжээ. Улмаар савирууд 465/466 оны үед Хар болон Каспийн тэнгисийн хоорондахь нутагт иржээ. Хожим нь буюу VI зуунд тэд голчлон одоогийн ОХУ-ын Халимаг болон Дагестанаар нутаглах болжээ.

Энэхүү савир аймгийн талаар нэг сонирхолтой санал байдаг, юу гэвэл, Хань-ийн үеийн сурвалжид ‘ухуань’, ‘сяньби’ аймгийг дурддаг бол Византийн

сурвалжуудад ‘авар’ ба ‘савир’ аймгийн тухай олж болно гэжээ. Чингэх нь “сяньби (сяньбэй) нэрийн жинхэнэ дуудлага нь ‘сэрби’/‘сэрви’ гэж сэргээгдэж болно гэсэн E.G.Pulleyblank-ийн саналд тулгуурлажээ (Кляшторный, 2005: 48).

**Хоёр. «Авар=Псевдоавар (558 он)»:** Авар нэрийн түүхэнд тодоор үлдсэн хоёр дахь тохиолдол бол 558 он бөлгөө. Аланы толгойлогч Сарозигаар дамжуулан нэр үл мэдэгдэх нэгэн бүдүүлэг аймгийнхан Лазикийн Византийн цэргийн захирагч нартай харилцаж улмаар эзэн хааны зөвшөөрлийг хүлээж аваад анх удаа 558 онд өөрийн элчийг Константинопольд илгээжээ (Macartney, 1944: 267; Артамонов, 2002: 125-126). Өөрийгөө Кандикх гэж танилцуулсан элчийн үсний хэв маяг этгээд ‘гөрмөл гээгтэй’ нэгэн байснаас нийслэл хотын оршин суугчдын анхаарлыг ихэд татжээ. Тэрбээр, түүнийг илгээсэн аймаг их хүчтэй, хоёр түмэн цэрэгтэй гэж өөрийн аймгийг өндөрт өргөн хэлсэн ба иймийн тул Византийн дайснуудыг дарж өгч чадна, энэ тусын хариуд Византи улстай энх тайван тогтоох хүсэлтэй гээд өөрийн аймгийн нэрийг ‘Авар’ гэдэг хэмээн өгүүлжээ.

Ингэж л судлаачдаас үлгэр зохиолгоход хүрсэн Авар аймаг түүхэнд нэрээ гаргаж эхэлжээ. Чухамдаа энэ л аварыг монголчуудтай (жоужаньтай) холбож үзэх нь нэн түгээмэл үзэгдэл байсаар иржээ. Тухайлбал, түрэгчүүд жуань-жуанийг богино хугацаанд ялан гарч ирсний дараа тэдний анд нөхөд, холбоотон болон боолууд туг, отгоо эзгүйрүүлэн орхиж, зарим хэсэг нь бүр Уралаас цааш Европ руу зугтан одож Унгарын тал нутагт очиж Авар нэрийг олжээ гэж үзэх нь түгээмэл (Саундерс, 1992: 26).

Г.Е.Грум-Гржимайло, түрэгт шахагдан Европ орсон авар ба жоужань нэг гэдэг таамаглалыг бүр J.Klaproth дэвшүүлсэн бөгөөд харин Saint-Martin, Marquart нар эдгээр аварыг жоужаньтай адилтгаж байгаа нь энэ [авар] ард түмний угсаатны онцлогийг тайлбарлах бус харин ч нэг нэртэй хоёр ч ард түмэн оршиж байсан гэх хачирхалтай онолыг бий болгосон гэж өгүүлжээ (Грум-Гржимайло, 1926: 176-177).

Византийн түүхч Theophane-ийн Chronographie-д: 6055 (563) оны VII сард Hermichions аймгийн хан Askel-ийн илгээсэн элч Византид ирснээр Аварын бас нэг нэрийн хувилбар гарч ирчээ. Кермичионс (Кермихионит) аймгийг E.Chavannes, “... түрэгийн өмнөх Жуань-жуань байж болох юм. Марквартын тайлбарласнаар, ‘кермичион’ нь, ‘өт’ гэсэн утгатай ираны ‘керм’ болон Авестэд гардаг ‘hyaonas’ [хион] гэх үгний нэгдэл, ‘хион’ы хувьд гэвэл ер нь IV зууны дунд үеэр Персийн хилийг түйвээж байсан Аммиен Марцеллиний мэдээнд дурдагддаг ‘chionitae’-тай адилтгаж болно” гээд ер нь ‘кермихионит’ бол персүүдээс жоужанийг нэрлэсэн нэр гэжээ (Chavannes, 1903. 231, 232.).

Харин E.G.Pulleyblank-ийнхээр бол, “Хожуу Хань-ийн үеийн авиа галиглалтад \*kh-тай жишээнүүд бий болж эхлэх бөгөөд харин Зинь шу [Цзинь шу]-д бид бас \*th-г олох бөлгөө. Энэ нь магадгүй хүннү нарын дунд, тэр цагт магадгүй монгол маягийн хэлээр ярилцаж байсан дорнод ху буюу өөрөөр хэлбэл Hsien-pi ба Wu-уан 烏垣 [wū yuən] (эсвэл 丸[wǎn]) M. ou-hwan < \*aĥ-hwan=Avar нарын нөлөө жин эрс ихэсч тэдэнтэй хольцолдож эхэлсний тусгал байж болох юм (Pulleyblank, 1962: 242). Түүний өгүүлснээр бол ‘авар’ нэрийн дор Дунхугийн нэг салаа болох ‘ухуань’ ө.х. эртний монголчууд байжээ гэж ойлгогдож байгаа нь түүхэнд 463 онд тэмдэглэгдсэн Авартай илүүтэй холбогдох бололтой.

Жуань-жуань (zuan-zuan) буюу жоужань (zou-zan)-ий нэрийн *ńziwǝn-ńziwǝn* болон *ńziǝu-ńziǝn* гэсэн сэргээлтээс H.W.Bailey, zuan-zuan-ийг илүүтэй онцлогийг

тусгасан хожуу хэлбэр, харин гадаад үгийн  $\upsilon$  эсвэл  $\beta$  гийгүүлэгчийг тэр үед нангиадууд  $ziw$  ба  $zi$  авиагаар тэмдэглэдэг тухай өгүүлжээ (Bailey, 1979: 209).

Эдгээр авар бол жоужань мөн гэх саналыг бусад судлаач хөгжүүлсээр байна. “Х.Шэдер жоужанийг табгачийн Тай У хаан *krenchendes Gewьrm* (мөлхөгч өт) гэсэн нь монголын аварга *Schlange* (могой) гэдгийн орчуулга мөн гэж үзээд, улмаар авар аймагтай холбосныг А.Коллауц, Х.Миякава нар баримталсан [бол] Г.Учида «Жоужань, авар хоёр нэгэн нэр болох тухай хэдэн асуудал» өгүүлэлдээ энэ хоёр нэр нэгэн болохыг тайлбарлан бичихдээ: ... б/ гулюй, юцзюйлюй нь алтай хэлний өт хорхой, гүрвэлзэн хөдлөх, мөн могой гэх мэтийн үгийн утгатай *quru, qurt, qoro* юм, в/ грекээр *abaroι, abares* гэж, латинаар *avari, avares* гэж тэмдэглэгдсэн авар гэх нэрийн язгуур нь «аварга» (могой) гэсэн үг юм” (Сүхбаатар, 1992: 173.) гэх зэргээр дөрвөн зүйл нотолгоог дурдсан гэж Г.Сүхбаатар эшилжээ. Жоужаний хааны ургийн ‘*Yüjiulu*’ ба тэдний угсааг үүсгэгч ‘*Mugulu*’-ийн ‘*jiulu*’ ба ‘*gulu*’-д түрэг болон монголын “могойн хөдөлгөөн”, “цагирагласан могой”, мөн тэрчлэн “чоно” гэдэг утгыг агуулсан ‘*qur*’ ‘*qurt*’ гэсэн үг үнэхээр байдаг гэж зарим судлаач үзжээ (Юй Тайшань).

Дундад эртний үед Европт нэвтэрсэн бүх нүүдэлчид финн-угор эсвэл түрэг байсан тул ‘телега/тэрэг’, ‘хоругвь’ гэсэн үгийг зөвхөн Авараас авч болно, учир нь эдгээр үг «Игорийн хорооны дуулал»-д тэмдэглэгдсэн байдаг, тэгээд ч V-VIII зууны ‘Ард түмний их нүүдэл’-ийн үеэр Европт нэвтэрсэн Азийн ард түмнээс хэн нь ч Европын түүхэнд ийм урт нөлөөлөл үзүүлж чадаагүй ажээ. Орос хэл дэх ‘обры’ буюу ‘авар’ хэмээх эгшиг солигдох шинж чанарыг агуулсан энэ угсаатны нэр нь өөрөө тус үгийг яахын аргагүй Алтай хэлний гаралтай болохыг зааж байна (Кёррер).

Европ руу зугтсан авар бол түрэгт цохигдон нангиад ба ‘мукри’ руу зугтсан авар биш бөгөөд харин Н.А.Аристовын хэлсэнчлэн энэхүү Европ руу зугтсан авар бол түргеш аймгийн нэг хэсэг мөн гэж нэлээд үндэслэлтэй таамаг дэвшүүлсэн хэмээн Г.Е.Грум-Гржимайло өгүүлсэн бол Peter A. Boodberg, “Византийн сурвалж дахь «жинхэнэ» аварыг *Yu-chiu-lii* 郁久閭-уш *jiü lí* (anc. \**juk-kjäu-li*“o)-тай адилтгах нь огт сонирхолгүй” хэмээн шууд няцаасан байдаг (Boodberg, 1939: 230). М.И.Артамонов, савируудыг нутгаас үлдэн хөөсөн «жинхэнэ авар» хэн байсан тухай асуудал өнөөг хүртэл шийдэгдээгүй л байна. Нангиад сурвалжаар бол VI-VII зуунд Зүүнгарт байсан ‘а-ба’ аймагтай ‘абар’-ыг холбох нь бүхнээс илүү үндэслэлтэй байж болох талтай. Учир нь грекүүд  $\beta$  (бета)-г ‘в’ гэж дууддаг ч түүгээр ‘б’ авиаг тэмдэглэдэг тул ‘*αβαροίς*’ гэдгийг ‘абар’ гэж уншина. Харин нангиад хэлэнд төгсгөлийн ‘р’ алга болдог тул нангиадаар энэ нэрийг ‘а-ба’ гэж дуудах ёстой гэж эрдэмтэд үздэг бөгөөд ийм нэртэй жижиг аймаг VI-VII зуунд Тэнгэр ууланд нутаглаж байсан гэжээ (Аристов, 1896: 310; Грум-Гржимайло, 1926: 176; Артамонов, 2002: 88).

Түүний дэвшүүлсэн таамаглалтай ойр байдлаар J.Hamilton өөрийн саналыг өгүүлсэн байдаг. Түүний саналаар бол Токуз-Огузын ‘Эдиз’ (*Ddiz*) аймгийг тэмдэглэсэн ханзны зарим нэг хувилбар ‘*Aw(a)r*’ буюу ‘*Авар*’ гэж унших боломж олгох бөгөөд Тан улсын үед ‘*Ddiz*’-ийг тэмдэглэсэн ‘*A-po* (ā bō) 阿跛 \*·*ε-b’uēt*-ийн оронд ‘*A-tie*’ 阿跌 \*·*ε-d’iet* гэж засварласан харин Сүй династийн үед ‘*A-pa*’ 阿拔 \*·*ε-b’wāt* гэж тэмдэглэж байсан ба энэ үгийн ‘*pa*’ 拔-г хожим засварлах явцад ‘*po*’ 跛-г, ‘*tie*’ 跌 болгосон агаад энэ зарчмаар бол ‘*A-pa*’ 阿拔 (\*·*ε-b’wāt* > \*·*ε-b’wār*) буюу Авар аймгийн нэр нэр болох ‘*Авар*’ болно гэжээ (Hamilton, 1962: 46-47).

Үүний зэрэгцээ Авар бол түргийш, тэлэ нарын нэг хэсэг биш харин ч тэдний урьд үед тухайн нутагт амьдарч байсан Юэбань нар байсан гэх санал бас бий. Энэ саналыг дэвшүүлэгч нь 450-460 аад онд Дорнод Туркестанд өрнөсөн түүхийн үйл явдал болон Умар Вэй улсын хааны ордонд Юэбаниас элчин ирж байсан баримтыг түшжээ. Түүнийхээр жоужаньчууд 434 онд өрнө зүгт Тохаристанд нэвтрэн кидари кушан нарыг довтолжээ. Чингэх үедээ Или голын сав газар нутаглагч Юэбань нарыг хүчтэй цохисон бололтой, учир нь Юэбаниас Умард Вэй улсад V зууны эхээр элчин их ирдэг байснаа гэнэт 448 оноос энэ харилцаа тасарсан гэнэ. Түүнчлэн Юэбань (*Yueban*) нэрийг *'jiuat-pean'* гэж галиглаад, энэ нь ямар ч эргэлзээнгүй Авар эсвэл апарын өөр орчуулга гэж үзжээ (Юй Тайшань).

Ийм саналыг шууд хэлээгүй боловч 'юэбань' аймгийн нэрийг 'варвализ' гэж галигладаг судлаачид бас бий, тухайлбал Г.Сүхбаатар ийн үзсэн байдаг (Сүхбаатар, 1992: 66).

Авар аймгийн талаарх гол мэдээллийг агуулж байдаг Византийн сурвалжид тэднийг бас 'Вархонит', 'Кермихионит' гэх нэрээр тэмдэглэгддэг. Эдгээр нэрийг үндэслэн зарим судлаач Авар нь иран аймгуудаас бүрэлдсэн гэж үздэг тал бий.

Авар буюу *var-*, *avar-*, *varvar-* нэр Камул (Хами) хотын умраас алс өрнө зүг Унгар хүртэл алдаршсан энэ аймгийн нөгөө нэр Вархонит-ын тухай, грекүүд *Οὐάρ* гэвэл 'эфгалит' аймгийг харин *Οὐάρ καί Χουννί* юм уу *Οὐάρχωνίται* гэвэл Европын авар нарыг нэрлэж байсан, энэ нэрийн *hōn* нь Заратуштрагийн (м.э.ө. 1000 он) үеийн Виштаспа хааны түүхийг өгүүлэх эртний Авест дэх *hyaona-*, хожуу пехлевийн *hyōn*, нангиадын *hiung-nu*, болон тэдний буддын ном зохиолын самгарьд үг *huna-* байх боломжтой гэнэ. Улмаар 'авар' нэрийн '*var*' бол иранаар 'хүч чадалтай байх, ялагч байх' гэсэн утгатай бол Авестийнхээр 'хүч' гэж ухагдана хэмээн Н.W.Bailey өгүүлжээ (Bailey, 1979: 208-209, 210).

Эдгээрээс үзвэл, нэгд, түүхэнд 463 онд тэмдэглэгдсэн 'авар'ыг, эртний монголчуудтай (ухуань/жоужань), **хоёрт**, 558 оны үед Византийн хилд нүүн очиж нутагласан 'авар'чуудыг мөн 'эртний монгол', болон 'юэбань' аймагтай бас 'тэлэ' (токуз-огуз), эсвэл 'түргийш', бүр Хами-ийн хойно нутаглаж байсан '*var*' аймагтай холбож болохоор ажээ.

**I.** Тухайн асуудлыг тодорхой төвшинд шийдэхийн тулд авар аймагт холбогдох түүхээс өгүүлэх нь зүйтэй болов уу. Гэхдээ, 558 онд түүхэнд тэмдэглэгдсэн аварыг хожим 570-590-аад онд, Феофилакт Симокатт, түрэгт очсон элч нарын мэдээлэлд тулгуурлан, тэд бол жинхэнэ авар биш гэдгийг анх удаа зөв танин мэдээд тэднийг 'Псевдоавар' гэж нэрлэвэл зохистой гэжээ. Тиймээс 558 онд түүхэнд тэмдэглэгдсэн 'авар'ыг, 463 онд 'савир' нарыг довтолсон аваруудаас ялгахын тулд Феофилакт Симокаттын 'Псевдоавар' гэсэн нэр томъёог хэрэглэнэ.

Төв Азид, 550-иад оноос эрс хүчирхэгжсэн түрэгүүдийн дарамтаас нэг хэсэг нүүдэлчин аймаг зугтсаар Хар тэнгисийн хойд эргээр нутаглаж байсан аймгуудын нутагт хүрэлцэн иржээ. Хожим Византид 568 онд анх удаа очсон Түрэгийн элчийн хэлснээр бол 552-558 онд тэднээс хоёр түм орчим 'псевдоавар' зугтсан гэнэ (Macartney, 1944: 267). Өөрөөр хэлбэл, "византичуудад түрэгүүдийн мэдээлснээр бол өрх гэр бүл бус харин зөвхөн **20 мянган цэргээс бүрэлдэх Аварын жижигхэн орд**, дайны ялагдлаас болж өөрийн нутаг [ар гэрээ] орхиж, нүүдэлчдийн хувьд [амьжиргааны] үндсэн эх булаг болсон мал сүрэг, нутаг бэлчээргүй болсноор маш хүнд байдалд оржээ. Цэвэр цэргийн байгууллага болсноор тэд [Хар тэнгисийн орчимд суурьшсан] нутгийн оршин суугчдад хамгийн аюултай дайсан нь болжээ".

Тэд үнэхээр тийм аюул учруулахуйц хүчин байсан гэж шууд утгаар нь ойлговол дэгсдүүлэл болно. Учир нь энэ үед (550-556 он), V зуунд жинхэнэ аварт ялагдсан 'савир'ын туг дор 12 мянган цэрэг, харин тэдний хөрш 'кутригур' аймаг мөн 12 мянган цэрэгтэй байжээ (Артамонов, 2002: 129, 95, 115). Гэтэл Хар тэнгисийн энэ бүс нутагт тухайн агшинд "утигур, оногур, угор, сарагур, болгар, акацир (хазар), дирмар" гэх мэтийн арваад аймаг «гунн» хэмээх ерөнхий нэр дор нутаглаж байсныг Сирийн түүхч Захар Ритор тэмдэглэж байсан тухай дээр өгүүлсэн билээ. Тиймээс Иоанн Малала (491-578 он), савирт бум орчим цэрэг эрс бий гэж өгүүлсэн нь ч нэлээд үндэслэлтэй болж таарч байна. Чухамдаа эдгээр аймгууд нийтдээ бум хүрэх цэрэгтэй гэсэн үг юм. Тиймээс псевдоавар нь тэдэнд хэт аюултай дайсан байсан гэж үзэх нь эргэлзээтэй, харин тэд эдгээр аймгуудын дунд эртнээс оршсоор байсан зөрчил, мөргөлдөөнийг гарамгай ашиглажээ. Энэ тухай ч түүхчид өгүүлсэн байдаг. Тус бүс нутагт тэднийг ирсний дараа өөр хоорондоо зөрчилдөгч аймгууд «жинхэнэ цэрэгжсэн орд» псевдоаваруудыг ашиглах гэж оролдсоноор тэд эдгээр аймгуудыг өөрийн манлайлал дор амархан нэгтгэсэн бололтой. Улмаар Византид итгэл олохын үүднээс тэдний бодлогыг эсэргүүцэгч хэд хэдэн (савир, барсил/сал, утургур, ант) аймгийг Юстинианы зөвлөснөөр довтолсон болжээ (Левченко, 1940: 87; Артамонов, 2002: 96, 129; Кёрпер).

Ингээд тэнхэрч хүчирхэгжсэн псевдоаварууд тун удалгүй Византигаас нутаг олгохыг гуйсан боловч Justinian I (527-565 он) хаан үл зөвшөөрчээ. Гэвч нэгэнт хүчирхэгжсэн псевдоаварууд Баян ханы удирдлагаар Панноний 'гэпид', 'ломбард' аймгийг довтлон эзэлж 565 онд Франкын хаан Зигиберт (Сигизберт)-ийг хүчтэй цохижээ. Псевдоаварууд ийнхүү Византийн хилд улс байгуулан сууж улмаар тус улсын хилийг байнга уулгалах болсон тул 573 оноос византчууд тэдэнд буман солид өгч хоёр орны хоорондын энхийн харилцааг тогтоон барих болов (Grousset, 1965: 224; Левченко, 1940: 101).

Хожим, Азиас дахин хэдэн аймаг Европт очсон ба тэд түрэгийн эсрэг босоод ялагдсан аймгууд байв. Энэ тухай Византийн түүхч Теофилакт (Theophylacte), "энэ үед [585-598 он] Tarniakh (Ταρνιάχ) болон Kotzagires (Κοτζαγίροι)\* нар түрэгээс алс зугтаж Европт ирсэн ба тэд ч гэсэн Ouag ба Khounni [Уархунни/Вархонит]-аас гаралтай юм. Бас Zabender (Ζαβενδέρ) нар Ouag ба Khounni нэг угсаатай гэж хэлцдэг. Ийм байдлаар аварт арван мянган эр нийлсэн" (Chavannes, 1903: 248) гэж өгүүлжээ.

Византийн эзэн хаан Маврикий (582-602 он)-н хаанчлалын тухай зохиолыг, Ираклий (610-641 он) хааны үед бичсэн түүхч Теофилактын бүтээлд, псевдоаварын тухай нэлээд нарийн мэдээллийг хадгалжээ. Тухайлбал, баруун түрэгийн Истеми-ийн хүү Дяньгу (Гарду шад)-аас Византийн эзэн хаан Маврикий-д 598 онд илгээсэн захидалд Теофилакт Симокаттын илтгэн өгүүлснээр бол дараах зүйлийг өгүүлсэн байдаг. Үүнд:

"Абдел (эфталит гэж нэрлэдэг тэд бүгдийн тухай би ярьж байна) аймгийн ахлагчдыг толгой дараалан бут ниргэсэн энэ хаан тэднийг ялан дийлж өөртөө захируулах эрхийг олжээ. Энэ ялалтдаа эрдэн Стемби хааныг холбоотон болгосон тэрээр 'авар' аймгийг боолчилжээ.

Зэрлэгүүд шиг Европт, Паннонд амьдарч байгаа бага судлагдсан тэр аваруудыг өгүүлж байна гэж хэнд ч бодогдуулахгүйн тулд би өгүүлж байна.

\* Marquart, (Die Chronologie der Alttürkischen Inschriften, p. 91) Ἐτὸςἄἄἄἄἄἄἄἄ Ἐὸδδῆῶδ-δᾶε ἄἄῆῶἄἄἄἄἄ ἄῤᾤ E.Chavannes үр дэдднἄἄἄἄἄ.

Истра дагуу амьдрагч зэрлэгүүд өөрсдийгөө ‘авар’ гэж хуурамчаар нэрлэжээ. Тэд хаанаас гаралтай тухай одоохондоо би өгүүлэхгүй.

Хаан өөрөө үйл ажиллагаа хэрэгжүүлж өөртөө ‘огор’ аймгийн хүмүүсийг дагуулсан. Эд бол өөрсдийн олон тооны хүмүүс ба бүрэн зэвсэглэж цэргийн дасгал сургууль хийдгийн ачаар хүчирхэгжсэн хамгийн хүчтэй аймгуудын нэг болно. Тэд дорно зүгт түрэгүүд ихэвчлэн ‘Хар’ хэмээн нэрлэдэг ‘Тиль’\* мөрөн урсдаг газарт амьдардаг. Энэ аймгийн эртний тэргүүнүүд нь ‘Уар’ ба ‘Хунн’ байсан. Тиймээс энэ аймгийн зарим нэг нь ‘уар’ ба ‘хунн’ нэр авсан. Эзэн хаан Юстиниан хаан ширээг эзлэж байсан цагт ‘уар’ ба ‘хунн’ аймгийн зарим нэг нь дутааж Европт суурьшсан. Өөрсдийгөө ‘авар’ гэж цоллоод өөрийн удирдагчаа хаан өргөмжилжээ. Тэд яагаад өөрсдийн нэрээ өөрчилсөн тухай бид үнэнээс огт гажилгүйгээр өгүүлнэ.

Барсельт, Уннугур, Савир болон тэднээс бусад гунн аймгууд тэдний нутагт ирсэн хэсэгхэн ‘уар’ болон ‘хунн’ хүмүүсийг хараад л айдас хүйдэст автсан бөгөөд тэдэн дээр аварууд нүүн ирчихэж хэмээн бодоцгоожээ. Тиймээс тэд эдгээр оргон зайлагчдыг хүндтэй бэлэг сэлтээр хүндэтгэхдээ өөрсдийнхөө аюулгүй байдлыг хамгаална гэж тооцжээ.

Уар ба хуннчууд тэдний хувьд нөхцөл байдал аятайхан бүрэлдсэнийг үзээд тэд, эд нарын тэдэнд элч илгээсэн алдааг ашиглаж өөрсдийгөө ‘авар’ гэж нэрлэсэн ба ‘авар’ нь хамгийн хөдөлгөөнтэй хүч чадалтай гэж тооцогддог байна.

Үнэхээр манай үе хүртэл янз бүрийн нэр хочоо хадгалсаар байгаа тэдний нэг хэсэг хуучин дадал ёсоор ‘уар’ харин бусад нь ‘хунн’ хэмээн нэрийдсээр байгаа эдгээр ‘хуурамч авар’ (хэрвээ тэднийг ингэж нэрийдвэл маш зохимжтой бөлгөө) нь өөрсөддөө аймгуудын дунд тэргүүлэх эрхийг өөрийн болгосон юм” (Артамонов, 2002: 125-126).

Баруун түрэгийг захирагч Тарду шадаас 598 онд Византийн эзэн хаан Маврикии Стратегиконд илгээсэн захидлаас үзвэл ‘Авар’ буюу ‘Псевдоавар’-ын жинхэнэ нэрийг ‘уар-хунн’ гэдэг байсныг төвөггүй мэдэж болно. Нэг хэсэг судлаач энэхүү ‘хунн’ нэрнээс шалтгаалж Аварын бүрэлдэхүүнд хүннүчүүд орж байсан гэдэг бол нөгөө хэсэг нь энэ ‘хунн’ нэрийг ‘тэлэ’-гийн есөн аймгийн нэг болох ‘хунь/кунь’ нар мөн гэж үздэг (Hamilton, 1962: 36, 54). Гэхдээ дийлэнх судлаач уул нэрийн ‘хион/хонит’ гэсэн хувилбарыг үндэслэн ‘эфталит’ аймагтай холбодог, жишээ нь K.Czegledy, Карпатын бүс нутгийн Аварыг, Эфталитийн эзэнт гүрний гол элемент болох Вархониттой адилтгаж болно гэж үзжээ (Liptak, 1983: 48).

Псевдоаварын байгуулсан улсад оршиж байсан аймаг угсааны бүтэц, дүр төрхийн талаар судлаачид дараах зүйлийг өгүүлжээ. Түүхийн баримтаар бол 601 онд Тисса голд болсон 2 удаагийн тулалдаанд олзлогдсон Аварын хаант улсын цэргийн хорин хувийг\* псевдо аварууд, тэн хагасыг нь славянчууд, харин үлдсэнийг нь кутригур, гепид болон бусад аймаг угсааныхан эзэлж байв (Артамонов, 2002: 131).

\* Óáíðèèàèð Ñèíèàððóóí áòðàíàí ÿíý áíèüà Н.W.Haussig, Áíðííà Óòðèàíòàíú Òàðèí áíèðíè ðàðèí J.Marquart, Òèè (Тил) ÿðíèèà Toglа (Обоè) áíèðíè ààèèðààààà áíè Ì.È.Àððàíííà íàðíí íèíí íòàèàà- ÿíý áíè Èàèè ÿðíè ðíýíýàýà. Áýðàýý ÿíýðýýð ÿíý áíèüà ðìðýàììà ‘Òàð’ ÿðíè àýà ÿðèèýà ààèíàí ìí áíè ÿíý íú ‘Òàð ÿð-èí’ ÿðíè ààèè ðíèè. ÿíý ðòòàè Ò.À.Çòàà, àðàáíí ðììð- Ààðàèèè: “ÿð-èí áíè ðíí ÿðíè ... ðììíèè òí íú ðàð” àýà àè-èà ààèíàí àýýà òèíààð VII çòòíà íàíàèààòòà ÿíý áíèüà Ààà (<íàí-d’iet<Etil) áòðó ÿðèè àýà ÿðèèýàýà ààèíàí ðíýíýàýý (Çòàà, 2004: 11).

\* ÿíà ðýðàèèí ðíí ÿð. ÿð-ìì àèèí òííà áòðààè ààèààà áíèíí.

Гэтэл антропологийн судалгаагаар европ төрхтнүүд нийт хүн амын 27.2 %-г, Норд буюу умард германууд 20.8%-г, эртний европ төрхтөн 3.9%-г, Кроманьон төрхтөн 18.2%-г харин европ монгол төрхтний холимог арьстан 4.8%-г, монгол төрхтөн 9.7%-г эзэлж байжээ. Монгол төрхтөн дотор Байгал, Зүүн хойд хятад, Соён гэсэн гурван бүлэг ноёлох дэд бүлэг болж байна. Харин Европ-Монгол төрхтний дийлэнх нь Енисейн арьстанд холбогддог гэнэ (Liptak, 1983: 50-51, 52, 80, 84-88).

**II. Дээр өгүүлсэн судлаачдын санал, сурвалжийн мэдээ, антропологийн хэрэглэгдэхүүнээс үзвэл,**

**Нэг. 463 онд түүхэнд тэмдэглэгдсэн Авар аймгийг:**

- Дийлэнхдээ жоужань буюу дундад эртний монгол аймагтай холбож үзээд, тус нэрийг «аварга» (могой), гулюй, юцзюйлюй буюу өт хорхой, гүрвэлзэн хөдлөх, могой гэх мэтийн үгийн утгатай *qugu*, *qurt*, *qoro* гэдэг монгол үгийн ийн орчуулга, мөн монголын “могойн хөдөлгөөн”, “цагирагласан могой”, мөн тэрчлэн “чоно” гэдэг утгыг агуулсан ‘*qur*’ ‘*qurt*’ гэсэн үг гэж тайлбарлажээ (Юй Тайшань).

- Зарим судлаач тухайлбал Э.Пуллиблэнк, энэ ‘авар’-ыг ‘ухуань’ байж болох юм гэсэн бөгөөд түүний энэ таамаглал хийгээд ‘ухуань’, ‘сяньби’ гэх нэрийн эрт үеийн дуудлагын сэргээлтэд тулгуурлан С.Г.Кляшторный, ‘авар’ буюу ‘ухуаньд’ хөөгдсөн ‘савир’ нь ‘сяньби/сяньбэй’ буюу ‘сэрби’/‘сэрви’ гэх маш эргэлзээтэй, ээдрээтэй таамгийг дэвшүүлжээ (Кляшторный, 2005: 48, 62).

- Энд дашрамын байдлаар өгүүлэхэд, хэдийгээр ‘сяньби’ нэрийг \**sdrbi*, \**srbi*, \**srvi* (Pelliot, 1934: 35) гэж сэргээж болох хэдий ч тэднийг Эрчис мөрний дунд биеэр нутаглаж байсан финн-угорын бүлгийнх байж болох ‘савир’-тай хутгаж болохгүй л болов уу. Тэгээд ч П.Пеллиогийн ‘сяньби’-ийг \**sdrbi*, \**srbi*, \**srvi* гэж сэргээснийг Ю.А.Зуев бас дэмждэг бололтой (Сүхбаатар, 1971: 34).

- Авар нь Тэнгэр уулын өмнөд бэлд, Юлдүүз голоос Нарийн гол хүртэлх нутгаар голлож, Или голын сав нутагт хяналтаа тогтоож байсан, түүхэнд баруун зүгт нүүсэн хүннүгийн удам гэж тэмдэглэгдсэн, 2 бум хүн амтай ‘юэбань’ аймгийн нэг хэсэг мөн гэсэн таамаглалыг баримтлагчид, жоужаний дарамт шахалт дор 448 оны хавьд ‘юэбань’ өрнө зүг нүүсэн гэжээ.

**Хоёр. 558 оны Авар буюу Псевдоавар:**

- Жоужань ба эдгээр авар нь нэг аймаг гэх хамгийн эртний таамаглал нь үндсэндээ ямар үндэслэлгүй зүйл болох нь батлагдаад байна.

- Эдгээр аварыг Византийн түүхийн зохиолуудад ‘псевдоавар’ гэж нэрлэсэн нь үнэндээ жинхэнэ аварчуудаас ялгахын тулд зохиосон нэр ажээ. Харин энэ аймгийн өөрсдийгөө нэрлэдэг нэр нь ‘вархонит’ бол персүүд ‘кермихионит’ гэж тэднийг нэрлэдэг байжээ.

- Вархонитыг, Хамигаас хойш нутаглаж байсан вар болон хион гэсэн 2 аймаг хэмээн Х.В.Бэйлэ үзсэн нь ‘эфталитын хунн’ нарын уугуул нутаг бол Алтайн уулс мөн гэж үзсэн Рэнэ Грүссэ-ийн саналтай тун ойрхон байна. Харин К.Цегледи, псевдоаварыг, Эфталитийн эзэнт гүрний гол аймгийн нэг Вархонит гэжээ (Bailey, 1979: 208; Grousset, 1965: 110; Liptak, 1983: 48).

- Н.А.Аристов, Г.Е.Грум-Гржимайло, Ж.Хамилтон, Ю.А.Зуев зэрэг нэлээд олон судлаач псевдоаварыг ‘түргиш’ эсвэл ‘тэлэ’ аймаг гэж үздэгээс ‘тэлэ’ аймаг гэх тайлбарыг үзвэл ‘вар’ буюу ‘авар’ бол тэлэгийн ‘аба’ (аде/эдиэ), ‘хионит/хунн’ нь



тэлэгийн ‘хунь/кунь’ мөн гэнэ. Харин Ю.А.Зуев, вархонитын араас нүүсэн ‘тарних’ аймгийг ‘дилээр’, ‘забендер’ аймгийг ‘шибань’, ‘котсагир’ аймгийг ‘коча’ аймаг хэмээн тайлбарлажээ (Зуев, 2004: 12).

**III.** Авар ба дундад эртний монгол аймгуудын холбогдол зарим судлаачын үзэхээр байж болох ажээ. Гэхдээ тийм байх боломж бий эсэхийг эхлээд нягталъя.

Далайгаас дэгдсэн их уур манан эсвэл үлгэр домгийн «грифон» гэх амьтны дэлгэрүүлсэн тахал, эсвэл хүний махан идэшт аймшгийн амьтнаас болж далайн эрэг орчмын манан будант нутгаа орхин Аварын нутагт довтолгон ирсэн хүчирхэг ард түмэн хэн байсан тухай дийлэнх судлаач өгүүлэхдээ, тэд бол ‘сяньби-табгач’ аймаг гэж үздэг.

Жоужань улсын Тухэжэний Чую-ийн 15-р он, Табгачийн Вэй улсын Тай-аний 4-р оны өвлийн дунд сард, Вэньчэн хаан туг хиур мандуулан, мянган ли газар үргэлжлэх буман морин цэрэг, түм таван мянган тэрэг хөсөгтэйгээр элсэн говийг амжилттай туулсан боловч дайсан болох жоужаний хаан Тухэжэнь алслан холдож чадсан ч түүний мофу түшмэл Учжухэтуй, Кушитуй нарын хэдэн мянган өрхийг тэрэгт цэргийн захирагч У Жу довтлон олзолжээ (Сүхбаатар, 1992: 36; Хандсүрэн, 2005: 121; Материалы ..., 1984: 276; Юй Тайшань). Гэвч жоужаньчууд тун удалгүй 460 онд Турфаныг довтлон эзэлсэн ба ‘юэбань’-ийг мөн энэ үед л довтолсон бололтой. Түүнчлэн энэ л үед Алтайг давж Эрчис мөрний дагуу суугч ‘савир’ыг довтлох боломжтой ажээ.

‘Жоужань’ нэрийн дүрс үсгийг ‘нөхөр/пццг’ гэж галигласан С.ЕЯхонтова-ийн аман зөвлөгөөг дэмжсэн С.Г.Кляшторный, “хээр талын эзэнт гүрэн ‘Нөхөр’-ийн гол угсаа-улстөрийн бүрдүүлэгчид нь авар (ухуань), сэрви/сэрби (сяньби) ба татар (датань) гэсэн өвөг монгол аймгууд нэгдэл...” байсан гэж үзсэн байна (Кляшторный, 2005: 58).

**IV.** Зарим судлаач одоо болтол ‘Авар’ нэрийг бүр хожим VIII зууны эхээр бүтээгдсэн Көлтигин, Билгэ хаан нарын дурсгалд зориулсан гэрэлт хөшөөнд нэр гарах ‘(А)пар’тай холбодог хэвээр л байна. Тухайлбал С.Г.Кляшторный, “Апар ба Пурумын элчийг дурдсан явдал нь Дундад Азитай ямар ч хамааралгүй, эхний нэр нь аварчуудын өөрсдийгөө нэрлэдэг, бүр тодорхой хэлбэл, Феофилакт Симокаттын мэдээ ёсоор псевдоаварын нэр” гэжээ (Кляшторный, 2003: 85; Юй Тайшань).

Түрэг язгууртан Көлтигинд зориулан ах Билгэ хаанаас нь бичин жилийн намрын тэргүүн сарын хорин долоонд босгуулсан гэрэлт хөшөөний их (зүүн тал) талын 4-р мөрөнд Баруун Түрэгийн хаан Истеми шадад зориулсан тахилгад олон улс орноос элч ирж хамт гашуудсан тухай дурсчээ. Энэ хэсэг бичвэр бараг тэр чигээрээ Билгэ хаанд зориулсан гэрэлт хөшөөний зүүн талын бичээсийн 5-р мөрд давтагддаг. Тэдгээрт:

*“... таалал төгсөв, уйлж хайлахаар, урд наран ургахаас Бөкли чөлиг эл\* ,*

*Табгач, Түнүт, (А)Пар, (А)Пурум, Кыркыз, Үч Курыкан, Отуз Татар,*

*Кытани, Татаби ... өдий төдий түмэн ирж хайлан уйлав”* (Малов, 1951: 36; Tekin, 1968: 264; Mehmet Tezcan; Базылхан, 1987: 51) гэж өгүүлдэг.

\* Ýý ý äeeä: áokli ÷ölai äl (Á.Ðaaäíä), bökli çölig il (Á.Öññái), bükli çölig el (Ö.Í.Íðóí), áokli ÷öl(í)ä il (Ñ.Á.Íäéíä), á°eeí ÷°e]e]iä ie (Á.Áeäädíä), bükli çöllüg el (Ö.Öäèè), bökli çöl[í]üg il (Í.Ýðäèí), Á°eeè ÷°eeä ýe (Á.Áaçüèöäí), Á°e;èè ×°e;ä ýe (Í.Áaçüèöäí) áýæ öýäýí ýíç nüðäýýí óíöñääd èðæýý.

“Магадгүй нас нөгчөөд удаагүй өөрийн эцэг Сильзибул хаан (Истеми)-д зориулж Турксанф хаанаас үйлдсэн тахилгын ёслолд оролцсон [Византийн] элч илд агсагч Валентиныг (576 он) дурсаж” «(А)Пурум» нэрийг бичээст тэмдэглэсэн гэж үздэг зарим судлаачийн саналаар бол бичээсийн энэ хэсэг Бумын хаантай холбогдохоос илүүтэй 574/576 онд нас барсан түүний дүү Истеми шадыг Билгэ хаан дурсан хэлснийг тусгажээ (Кляшторный, 1964: 73; Mehmet Tezcan).

Францын судлаач Lyon Cahun өөрийн бүтээлдээ Апар нарын тухай өгүүлснийг, зохиолд нь шүүмж бичсэн В.В.Бартольд эш татсан байдаг. Түүнд “Орхоны бичээст дурдах нууцлаг ард түмэн *пар-пурым* (эсвэл *апар-анурым*)-ыг ноён Каён (105-р талд) хорасанчуудтай адилтгасан учир нь армян сурвалжид Нишапур хот байгуулагдсан тэр нутаг нь Апар нэртэй байсныг тэмдэглэжээ” (Бартольд, 1968: 245) гэснээс үзвэл хамгийн анх тэр Апар ба Хорасаны Апар нутаг хоёрыг адилтгасан боловч Пурум нэртэй хольсон байна.

Апар нэр руни бичигт нэг бус удаа дурдагдсан байж болох талтай учир түүний нэрийг Келтигинийг нас барахад ирж гашуудсан улс түмний төлөөлөгчид дотор хоёрдахь удаагаа дурдсан гэж үзэж болохоор нэгэн тайлбарыг судлаач Ричард И.Фрай дэвшүүлжээ. Түүний өгүүлэх нь: “...энэ үгийн сүүл хэсгийг ‘ѣдкдг<ѣакдг’ гэж уншсан Пол Пеллиогийн саналыг дагаад би энэ үгийг ‘Абар ѣдкдг’ юм уу эсвэл ‘Апар ѣдкдг’ гэж сэргээж унших санал тавьж байна...[гээд] улмаар энэ санал нь бэрхшээлээс ангид байхгүй нь мэдээж боловч түүнийг урьд сэргээж уншихдаа ‘перс’ хэмээн оноосноос хэл болон түүхийн бэрхшээлтэй асуудлыг илүү бага үүсгэнэ гэж найдаж байна. Нангиад сурвалжаар бол Самарканд ба Бухарын шилдэг цэрэг дайчдыг тэр үед 柘羯-tǰia \*k’wt=čākaḡ гэж нэрлэдэг байсан гэжээ, өөрөөр хэлбэл [Келтигиний хөшөөний бичээсийн] Апар ѣдкдг-ийг Апарын анги салбар эсвэл дайчин гэж сэргээж уншмаар байна” (Frye, 1956: 110-111) гэжээ. Түүний энэ саналыг ер нь мөн бусад судлаачийн саналыг нягтлан үзээд С.Г.Кляшторный тус үг нь Согд Бухараас цагаачлагчдаас Долоон Усны баруун хэсэгт байгуулсан хотуудын төлөөлөгч гэсэн утгатай хэмээжээ (Кляшторный, 1964: 126-131).

Тиймээс түрэгүүд ялангуяа зүүн хөх түрэгүүд, Апар нэрийг дахин нэг их хэрэглээгүй бололтой.

Ер нь Апар нэр Авартай холбогдох үндэслэл бас бага байдаг бололтой. “Зарим нэг эрдэмтэн Раг хэмээн унших гэж хичээдэг, саяхан Серткаая, [тус үгийг] Раг гэж давтаж уншихдаа Дөрфэрийн [түрэгийн \*р нь их төлөв уйгурын -р- шиг харин түрэгийн, ‘а’ авианы дараах \*b авиа гол төлөв уйгурын ‘w’ шиг дуудагддаг гэж] түрэгийн хэл шинжлэлийн талаар өгүүлснийг үндэс болгосон байна. Орхоны түрэг бичээс дэх үгийн эхний а/д [‘а’ ба ‘э’] авиа дуудагддаггүй боловч П.Аалто-ийн эртний түрэг, монголын талаарх шүүмж ёсоор бол харь гарвалтай үг заавалчгүй ‘Апар’ шиг уншигдах ёстой [тэгээд ч] түрэг, монгол хэлний язгуур хуучин үгүүдэд эхний -р- авиа дуудагдана гэжээ”. Сүүлийн үед судлаачид Апар бол Ром болон Цинь, Хань-ийн адилаар Дундад Ази, Иранд эзэнт гүрэн байгуулсан Парфян аймаг нэгэн цагт суурьшиж байсан Парни/Апарни мужийн хожмын хувьссан нэр гэдэгтэй санал нэг болж байх шиг байна. Үүнийг батлах баримтууд V-VII зууны Армян сурвалж бичгүүдэд хадгалагдан үлдсэнийг судлаачид илрүүлсэн байна (Mehmet Tezcan).

Түрэгийн үеийн монгол аймгуудын түүхтэй холбогдсоор ирсэн Авар, Псевдоавар, Апар нэрийн талаарх олон судлаачийн саналыг нэгтгэн үзвэл:

**Нэг**, V зууны авар, юэбань (варвализ эсвэл 'jiuat-pean') байж болох хэдий ч Жоужань ялангуяа Ухуань аймагтай ямар нэг байдлаар холбоотой бололтой. Тийм ч боломжийг зарим түүхэн мэдээ олгож байна. Тухайлбал, Жоужань ба Табгачийн Вэй улсын хооронд 458 онд болсон дайн.

**Хоёр**, харин Псевдоавар нь үндсэндээ дараах овог аймгийг өөртөө багтаасан аймгийн холбоо байсан бололтой. Үүнд:

- Псевдоаварын ноёлох гол аймаг нь Авар буюу Вар эсвэл А-ба болон Хун буюу Хунь хэмээх тэлэ аймгуудын хэсгээс бүрэлджээ. Тэд эрт цагаас эхлээд хүннү, дараа нь сяньби, харин 480-аад оноос эфталитын иран аймгуудтай ихээхэн өргөн дэлгэр харилцаатай байж тэдэнд захирагдаж ирсэн тул тэдний дунд хүннү, сяньби, иран элемент байсаар ирсэн гэж үзэж болно. Ингэвэл Псевдоаварыг нэг бол тэлэ эсвэл иран хэлтэн байсан гэх зөрүүтэй хоёр саналыг уусган арилгах боломжтой. Гэхдээ ийм дүгнэлтийг хүчээр гаргаж ирсэн гэж ойлгож болохгүй.

- Түүнчлэн Псевдоаварын дунд маш цөөн тооны баруун Шивэрийн палеоази төрхийн финн-угор эсвэл самоед хэлтэй хүмүүс байсан бололтой.

Гурав, Апар нэрийн тухайд гэвэл:

- Апар ба Авар хоёр өөр тусдаа зүйл байна. Өөрөөр хэлбэл, авар гэж нэг аймаг угсаатныг нэрлэсэн нэр бол Апар нэрийн хувьд энэ топоним болж байна.

- Апар гэж Хоросан мужийн нэгэн газрыг нэрлэдэг бөгөөд үндсэндээ эртний Парфянчуудын нутаг болох Парни/Апарни муж ажээ.

## НОМ ЗҮЙ

*Аристов Н.А.*, 1896. Заметки об этническом составе тюркских племен и народностей. ЖС. вып. III, IV.

*Артамонов М.И.*, 2002. История Хазар. Изд. второе, СПб.

*Базылхан Б.*, 1987. Күл-тегиний хөшөөний бичээсийн монгол орчуулга. SLL. Том. XVI, Fasc. 5, УБ.

*Бартольд В.В.*, 1968. Рецензия на книгу: L.Cahun. Introduction a l'histoire de l'Asie (1896). Сочинения. Том. V. М.

*БНМАУ-ын түүх*, 1966. Тэргүүн боть. Нэн эртнээс ХҮШ зуун. УБ.

*Грум-Гржимайло Г.Е.*, 1926. Западная Монголия и Урянхайский край. Том второй. Исторический очерк этих стран в связи с историей Средней Азии. Л.

*Зуев Ю.А.*, 2004. Каганат Се-яньто и кимеки. Shygy. <sup>1</sup>

*Ишжамц Н.*, 1998. Жужаны хаант улс (IY-YI зуун). Монголын түүхийн зарим өгүүллийн эмхтгэл. УБ.

*Кёррер Н.*, Погибоша Аки обре. Этнология. <http://his.1september.ru>

*Кляшторный С.Г.*, 1964. Древнетюркские памятники как источник по истории Средней Азии. М.

*Кляшторный С.Г.*, 2003. История Центральной Азии и памятники рунического письма. СПб.

*Кляшторный С.Г., Савинов Д.Г.*, 2005. Степные империи древней Евразии (Исторические исследования). СПб.

*Левченко М.В.*, 1940. История Византии. М-Л.

*Малов С.Е.*, 1951. Памятники древнетюркской письменности. Тексты и исследования. М-Л.

*Материалы по истории древних кочевых народов группы Дунху*. 1984. Введение, перевод и комментарии В.С.Таскина. М.

*Монгол Улсын түүх*, 2003. Тэргүүн боть. УБ.

- Саундерс Ж.Ж.*, 1992. Монголын байлдан дагууллын түүх. Англи хэлнээс орчуулсан Ж. Гэндэндарам. УБ.
- Сүхбаатар Г.*, 1971. Сяньби нарын угсаа гарал соёл аж ахуй нийгмийн байгуулал (Нэн эртнээс м.э. IV зуун). УБ.
- Сүхбаатар Г.*, 1992. Монгол Нирун улс (330 орчим-555 он). УБ.
- Хандсүрэн Ц.*, 2005. Жужаны хаант улс ба түүхийн зарим судалгаа. УБ.
- Юй Тайшань*, Рассуждения о теории родственности Rouran и Аваров, а также мнение, что Авары это Yueban. (Перевод на русский язык Н.В.Великановой.)  
<http://www.human.ru>
- Bailey H.W.*, 1979. North Iranian problems. BSOAS. Vol. 42, No 2. London.
- Boodberg Peter A.*, 1939. Marginalia to the histories of the Northern Dynasties. HJAS, Vol. IV, No. 3/4. Harvard.
- Chavannes E.*, 1903. Documents sur les Tou-kiue (Turcs) Occidentaux. Saint-Petersbourg.
- Frye Richard N.*, 1956. Notes on the history of Transoxiana. HJAS. Vol. XIX, No1/2. Harvard.
- Grousset R.*, 1965. L'Empire Des Steppes. Attila, Gengis-Khan, Tamerlan. Quatrième Édition, Paris.
- Hamilton J.*, 1962. Toquz-Oғuz et On-Uyғur. JA. Tome CCL, Fasc. No 1, Paris.
- Liptak P.*, 1983. Avars and Anceint Hungarians. Budapest.
- Macartney C.A.*, 1944. On the Greek Sources for the History of the Turks in the Sixth Century. BSOAS. Vol. XI, 12. London.
- Mehmet Tezcan*, The Ethnonym Apar in the Turkish inscriptions of the VIII Century and Armenian Manuscripts. pp. 2-3 <http://www.transoxian.org>
- Pelliot P.*, 1934. Tokharien et Koutchйen. JA. Vol. CCXXIV. Paris.
- Pulleyblank E.G.*, 1962. Appendix The Hsiung-nu Language. Asia Major. New Series. Vol. IX.
- Tekin T.A.*, 1968. Grammar of Orkhon Turkic. Indiana University, UAS, Bloomington.

### РЕЗЮМЕ

Б.Батсүрэн

### ОБ АВАРАХ, (ПСЕВДО)АВАРАХ И АПАРАХ

В статье проведено сравнительное исследование 'авар'-ов, отмеченных в западноевропейских источниках V в., и 'псевдоавар'-ов, отмеченных в византийских источниках VI в. Автор приходит к выводу, что между ними нет этногенетических связей, и также отмеченный в рунических памятниках 'апар' не является этнонимом, а названием местности в области Хорасан в Иране.